

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН
ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУЛГУУР УУРХАЙ
БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИ




2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АЛТАН ЭРДЭНИЙН ЦОМ
2024 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ
ХАМГИЙН САЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ КОМПАНИ

АГУУЛГА

01	Компанийн ерөнхий танилцуулга	4-6
02	Төлөөлөн удирдах зөвлөлийн мэндчилгээ	7
03	Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	8-9
04	Үйл ажиллагааны үр дүн	10-14
05	Санхүүгийн үр дүн	15
06	Худалдан авалтын үр дүн	17
07	Хөрөнгө оруулалтын үр дүн	18
08	Компанийн засаглал	19-20
09	Компанийн бүтэц	21-22
10	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй	23-24
11	Байгаль орчны хяналт, нөхөн сэргээлт	25-27
12	Хүний нөөц	28-29
13	Онцлох үйл явдлууд	30-40
14	Аудитлагдсан санхүүгийн тайлан	41-46





КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Компанийн оноосон нэр	“Багануур” хувьцаат компани
Үүсгэн байгуулагдсан он	1978 он
Компанийн албан ёсны хаяг	Монгол Улс, Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо Үйлдвэрийн хэсэг, “Багануур” ХК-ийн байр Утас: (976)-70210114, (976)-70213739 Факс: (976)-70213130 Э-шуудан: bjsc@baganuurmine.mn
Үйл ажиллагааны чиглэл	Нүүрс олборлох, борлуулах, боловсруулах Алтны шороон ордыг ашиглах Цайны газар Гадаад худалдаа
Бүртгэгдсэн бирж	Монголын хөрөнгийн бирж
Компанийн нийт гаргасан хувьцааны тоо	20,974,360 ширхэг
Компанийн удирдлага	ТУЗ-ийн дарга: Чулуунбаатарын Дондогмаа Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч: Дашдаваагийн Түвшинжаргал
Ажилтнуудын тоо	1,122
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Жилд 4.0 сая тонн нүүрс олборлох, борлуулах
Томоохон нийлүүлэгч байгууллага	“ДЦС-4” ТӨХК, “ДЦС-3” ТӨХК, “ДЦС-2” ТӨХК, “Амгалан ДС” ТӨХК, “Эрдэнэт ДЦС” ТӨХК, “Дархан ДЦС” ТӨХК, “Багануур ДС” ТӨХК, Орон нутгийн дулааны станцууд



КОМПАНИЙН ТУХАЙ

“Багануур” ХК нь анх 1978 онд 200.0 мян.тн нүүрс олборлох хүчин чадалтай “Багануурын нүүрсний түр уурхай” нэртэйгээр гараагаа эхэлж, эдүгээ 46 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

Багануурын уурхай нь төвийн урагш чиглэсэн суналтын дагуу уртаараа бүсийн эрчим хүчний станцууд болох 12 км, өргөнөөрөө 4-5 км талбай “ДЦС-4” ТӨХК-ийн 50%, “ДЦС-3” ТӨХК, эзэлж мульд маягаар тогтсон үндсэн ДЦС-2 ТӨХК-ийг 100%, “Дархан”, 3 давхаргаас бүрдэнэ. Багануурын “Эрдэнэт” ДЦС-ийг 10-30%, Багануур, Төв нүүрс нь эрчим хүчний зориулалттай аймаг, Сэлэнгэ, Хөтөл тосгоны дулааны Б2 маркийн нүүрсэнд хамаарна. станцууд болон уурын зуухнуудыг Нүүрсний үнслэг нь 12-17%, чийглэг нь 100% эрчим хүчний нүүрсээр ханган 28-33%, хүхрийн агуулга нь 0.4%, дулаан ажиллаж байна. Багануурын уурхайн гаргах илчлэг нь 3200-3600 ккал/кг. нүүрс олборлолтын жилийн хүчин чадал 1978 онд баталсан тооцоогоор нүүрсний 4.0 сая.тн боловч өнөөдрийн байдлаар нөөц 599.0 сая.тн 1988 онд нарийвчилсан дотоодын хэрэглэгчдийн нүүрсний хайгуул хийж ордын баялаг нөөцийг 708.2 хэрэгцээнээс хамаарч жилд 4.9 сая.тн сая.тн болгосон. 2014-2015 онд Дэлхийн нүүрс олборлож төслийн хүчин чадлыг банкны хөрөнгө оруулалтаар Багануурын 22.5%-иар нэмэгдүүлэн Монгол Улсын нүүрсний ордын гүйцээх хайгуулын эрчим хүчний нүүрсний хэрэглээний ажил хийгдэж балансын нөөцийг 280.0 47 хувь, төвийн бүсийн хэрэглэгчдийн сая.тн-оор нэмэгдүүлж Олон улсын JORC 52 хувийг дангаараа хангаж байна. стандартаар үнэлэгдсэн нийт 812.0 сая.тн Нүүрсний орд нь зүүн хойноос баруун баталгаат нүүрсний нөөцтэй болсон.

Багануурын нүүрс нь физик, химийн шинж чанараараа эрчим хүчний зориулалтаар ашиглагдахаас гадна цаашдаа дахин боловсруулалт хийгдэх, метан, шатдаг хий, түлш, шингэн ба шахмал түлш болон бусад хими технологийн түүхий эд болох бүрэн боломжтой нь судалгаагаар батлагдсан.

АЛСЫН ХАРАА

Монгол Улсын нүүрсний салбарын чиг хандлагыг тодорхойлогч байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Тогтвортой хөгжлийг хангасан, мэдлэг инновацад суурилсан үндэсний тэргүүлэгч компани болно.

ҮНЭТ ЗҮЙЛС



Бид хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг нэн тэргүүнд тавьдаг



Бид мэргэжилдээ хүндэтгэлтэй хандан санаачилгатай байж шинэ шийдэл ажлын шинэ арга замыг бүтээлчээр хөгжүүлж мэргэжлийн өндөр түвшинд үйл ажиллагаа явуулахын тулд мэдлэг ур чадвараа байнга дээшлүүлдэг



Бид зөв зүйлийг хийж, шударга ил тод байдаг. Өөртөө болон бусдад зарчимч байдлаар хандаж шударга бус байдалтай үл эвлэрнэ



Бид харилцан итгэлцэл хүндлэлийг бий болгон хүн бүр багийн нэг хэсэг болж үр дүнтэй хамтран ажилладаг



Бид үүрэг хариуцлагаа ухамсарлаж хийж буй үйлдэл хэлсэн үгэндээ эзэн болдог.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын эрчим хүчний нүүрсний хэрэгцээний 60 хувийг дангаараа хангаж, улс орныхоо эрчим хүч, дулаан хангамжийн системд томоохон хувь нэмэр оруулан ажиллаж байгаа “Багануур” ХК нь 2024 онд түүхэндээ хамгийн өндөр буюу 4.9 сая.тн нүүрс олборлон, 1.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 20 жилийн дараа анх удаа хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан түүхэн жил болж өнгөрлөө.

Компанийн ажилтнуудын нийгэм, эдийн засгийн баталгааг хангах зорилгоор Эдийн засаг нийгмийн хөгжлийн сангийн журмыг 10 жилийн дараа шинэчлэн баталж, хамрах хүрээг өргөжүүлснээр 23 ажилтанд санхүүгийн дэмжлэг, сургалтын тэтгэлэг олгосон байна.

Түүнчлэн компанийн засаглалын тогтолцоог сайжруулах зорилго бүхий Компанийн залгамж халааны бодлого, комплайнсын хяналтын загварыг анх удаа баталсан нь сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх нэг ахлам боллоо.

Багануур ХК нь 2024 онд нүүрс олборлолт, борлуулалтын төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн нь уурхайчин хамт олны хичээл зүтгэл, хариуцлага, үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалт, төлөвлөлтийн үр дүн гэдгийг ОНЦЛОН ТЭМДЭГЛЭЖ, Монгол Улс, нийслэл Улаанбаатар хотын хөгжил, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Эрчим хүчний сэргэлт, Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж, оюун ухаан, мэдлэг чадвар, туршлага, хүч чадлаа дайчлан ажиллаж байгаа уурхайн нийт хамт олондоо талархсанаа илэрхийлье.

Багануурын уурхай нь Эрдэнэс Монгол нэгдлийн шинэ стратеги төлөвлөлтийн хүрээнд уурхайн үнэт зүйл болох чадварлаг, мэргэшсэн уурхайчид, ажилтнаа эрхэмлэсэн, тэргүүлэх технологи, инновацыг нэвтрүүлсэн, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, сайн засаглалыг хангасан, хариуцлагатай уул уурхайг бэхжүүлсэн Монгол Улсын нүүрсний салбарын чиг хандлагыг тодорхойлох үндэсний тэргүүлэгч компани болох эрхэм зорилгодоо амжилттай хүрч чадна гэдэгт илтгэлтэй байна.

Та бүхэнд эрүүл энх, ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



ДАШДАВАА ТҮВШИНЖАРГАЛ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Эрхэм хүндэт Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, харилцагч байгууллагууд та бүхнийхээ амар мэндийг эрэн мэндчилье.

Эрдэнэс Монгол нэгдэл 2024 оныг “Хэрэгжилт үр дүнгийн жил” болгон зарласантай холбогдуулан бид хөдөлмөрийн болоод санхүүгийн сахилга батыг сайжруулах, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, үр ашигтай төсөл хөтөлбөрүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, дунд хугацааны ТЭЗҮ-тэй уялдуулан техник, технологийн шинэчлэл хийх,

ажилтнуудын нийгмийн тулгамдсан асуудлуудыг үе шаттайгаар шийдэх зэрэг зорилтуудыг тавин ажиллаж тодорхой үр дүнд хүрлээ.

“Багануур” ХК 2024 онд 4,957.4 мян. тн нүүрс олборлон төлөвлөгөөг 102.3 хувь, 4,916.1 мян.тн нүүрс борлуулж төлөвлөгөөг 101.5 хувиар биелүүлэн компанийн түүхэнд хамгийн өндөр борлуулалт хийж, 1.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Ашигт ажиллагааны үр дүнд 18 жилийн турш хуримтлагдсан Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг бүрэн төлж дуусгалаа. Мөн 2019-2021 онд Монгол Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны банкны зээлээр хэрэгжүүлсэн техник шинэчлэлийн 23.5 тэрбум төгрөгийн өрийг 2024 онд бүрэн төлж тэглэлээ.

4.9 САЯ.ТН

46 жилийн түүхэнд хамгийн их олборлолт, борлуулалтыг хийв.

1.7 ТЭРБУМ

Цэвэр ашигтай ажиллав.

33.8 ТЭРБУМ

Хөрөнгө оруулалтыг өөрийн хөрөнгөөр хийв

23.5 ТЭРБУМ

2019-2021 оны хооронд авсан JBIC-ийн зээлийн өр төлбөрийг бүрэн тэглэв

24.0 ТЭРБУМ

18 жилийн хугацаанд хуримтлагдсан Нийгмийн даатгалын өр төлбөрийг бүрэн тэглэв

50.7 ТЭРБУМ

Төсөвт төвлөрүүлэв

Эрдэнэс Монгол нэгдэл 2024 оны нэгдлийн ололт амжилтаа дүгнэж “Эрдэнэсийн цом”-ын эздийг тодруулав. Эрдэнэс Монгол Нэгдлийн бүрэлдэхүүн, Монгол улсын эрчим хүчний тулгуур уурхай Багануур ХК менежментийн үйлчилгээний үр дүнд өсөн нэмэгдэж буй эрчим хүчний системд шаардлагатай түлшийг амжилттай нийлүүлж, үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг сайжруулсан, ашигт ажиллагааг нэмэгдүүлж, нэгдлээс зохион байгуулсан томоохон арга хэмжээнүүдэд манлайлж оролцсон үзүүлэлтээр 2024 оны “Алтан эрдэнийн цом”-ын эзэн болсон. Эрдэнэс Монгол нэгдлээс 2025 оныг “Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан уурхайчин хамт олон бид 2025 онд 5,000 мян.тн нүүрс олборлон борлуулж, 6.0 тэрбум төгрөгийн ашигтай ажиллахаар бизнес төлөвлөгөөгөө ТУЗ - өөр батлуулан, жилийн эхнээс

үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөө үзүүлэлт бүрээр биелүүлэн ажиллаж байна.

Мөн бид 2025 оноос эхлэн олборлосон нүүрсээ боловсруулан Хөх нүүрс гаргаж Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, Амоны нитрит үйлдвэрлэж Монгол Улсын тэсэлгээний бодисын зах зээлд оролцох, LNG буюу газ үйлдвэрлэх Багануур УТП-ийн төслийг Монгол Улсын Засгийн Газрын дэмжлэгээр Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс УТП ХХК-тай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна. “Багануур” ХК-ийн уурхайчин хамт олон бид тасралтгүй, байнгын үйл ажиллагаатай, өндөр зохион байгуулалт, эв нэгдлийг эрхэмлэж, технологийн горим, ажлын хариуцлага, сахилга дэг журам, эмх цэгц, ёс зүйг өндөр түвшинд байлган, өмнөө тавьсан зорилтоо хэрэгжүүлж, зорилгодоо хүрэхээр хамтран зүтгэх болно.

Газар эхийн хээлэнд шүтэж, гал эрдэнийн тахил өргөж, эх орон элгэн түмэндээ илч гэрэл түгээж байдаг уурхайчид биднийг үргэлж дэмжин ажилладаг Төлөөлөн удирдах зөвлөл, Эрдэнэс Монгол нэгдэл, харилцагч, хамтран ажиллагч байгууллагууд нийт Монголын ард түмэндээ талархал илэрхийлье.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ТҮВШИНЖАРГАЛ

НҮҮРС ОЛБОРЛОЛТ /мян.тн/
4,957.4 **102.3%**

НҮҮРС БОРЛУУЛАЛТ /мян.тн/
4,916.1 **101.5%**

ХӨРС ХУУЛАЛТ /мян.м³/
19,183.2 **91.8%**

ХӨРС ХУУЛАЛТ /мян.м³/
30,633.0 **97.5%**





ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

УУЛЫН АЖИЛ

2024 онд Багануур ХК нь 20,890.0 мян.м³ хөрс хуулж 4,844.0 мян.тн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулан гүйцэтгэлээр 19,183.3 мян.м³ хөрс хуулж 91.8%, 4,957.4 мян.тн нүүрс олборлон 102.3%, 4,916.1 мян.тн нүүрсийг борлуулж 101.5%-ийн гүйцэтгэлтэй ажилласан.

Уулын ажлын гүйцэтгэл



Уулын ажил	Х/н	2023 он	2024 он			
			төлөв	гүйцэт	хувь	зөрүү
Нүүрс олборлолт	мян.тн	4,648.4	4,844.0	4,957.4	102.3	113.4
Нүүрс борлуулалт	мян.тн	4,628.1	4,844.0	4,916.1	101.5	72.1
Хөрс хуулалт	мян.м ³	17,866.7	20,890.0	19,183.3	91.8	-1,706.7
Нийт уулын цул	мян.м ³	29,098.1	31,412.3	30,633.0	97.5	-779.3

НҮҮРС ОЛБОРЛОЛТ

Эрчим хүчний хэрэглээ жилээс жилд өссөн нэмэгдэж байгаа энэ цаг үед 2024 онд 4,844.0 нүүрс олборлохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 4,957.4 мян.тн нүүрс олборлож төлөвлөгөөгөө 102.3%-иар давуулан биелүүлсэн нь өмнөх оноос 309.0 мян.тн, төлөвлөлтөөс 113.4 мян.тн-оор илүү олборлож түүхэн дээд амжилт гаргасан.

Нүүрс олборлолт /сая.тн/

Хэсгүүдийн нүүрс олборлолтын эзлэмж /хувь/



НҮҮРС БОРЛУУЛАЛТ


Хэрэглэгчдээс ирсэн захиалга, өмнөх жилүүдийн тоон үзүүлэлтэд тулгуурлан 2024 онд 4,844.0 мян.тн нүүрс борлуулахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 4,916.1 мян.тн нүүрс нийлүүлж төлөвлөснөөс 72.1 мян.тн-оор илүү борлуулалт хийж, төлөвлөгөөгөө 101.5%-иар давуулан биелүүлсэн.

Тайлант хугацаанд хэрэглэгчдэд нийлүүлсэн нүүрс /мян.тн/

Хэрэглэгчид	2024 онд			
	Төлөв	Гүйц	Хувь%	Зөрүү
“ДЦС-4” ТӨХК	2,355.0	2,388.3	101.4%	33.3
“ДЦС-3” ТӨХК	1,555.0	1,581.8	101.7%	26.8
“ДЦС-2” ТӨХК	285.0	282.0	98.9%	-3.0
“ДДЦС” ТӨХК	139.0	153.2	110.2%	14.2
“Амгалан ДС” ТӨХК	50.0	45.3	90.6%	-4.7
“ЭДЦС” ТӨХК	15.0	18.1	120.7%	-3.1
“БНДС” ТӨХК	73.8	67.6	91.6%	-6.2
“Налайх ДС” ТӨХК	36.1	37.2	103.0%	1.1
“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ	55.7	37.1	66.6%	-18.6
“Төв чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ	26.1	28.9	110.7%	2.8
“Хөтөл энерги дулаан” ХХК	-	6.6	-	6.6
“Хэнтий ус” ОНӨААТҮГ	-	19.5	-	19.5
Бусад /жижиглэн/	253.3	250.5	98.8	-2.8
Нийт дүн	4,844.0	4,916.1	101.5	72.1

Нүүрс олборлолт /сая.тн/


Хэрэглэгчдэд нийлүүлсэн нүүрсний борлуулалт /хувь/



ХӨРС ХУУЛАЛТ

Жилийн эхнээс 20,890.0 мян.м³ хөрс хуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 19,183.32 мян.м³ буюу 91.8% гүйцэтгэлтэй ажилласан. Нийт хөрс хуулалтын ажилд авто тээвэртэй хөрс хуулалт 17,285.5 мян.м³, тээвэргүй хөрс хуулалт 1,673.7 мян.м³-ийн гүйцэтгэлтэй байна.

2024 онд 19,183.2 мян.м³ хөрс хуулсан нь сүүлийн 4 жилийн дунджаас 1,154.2 мян.м³ буюу 6.4%-иар өссөн. Тээвэртэй ашиглалтын системээр нийт хөрс хуулалтын ажлын 91.1%-ийг, тээвэргүй хөрс хуулалтын системээр 8.9%-ийг гүйцэтгэсэн байна.



495.5 САЯ ТӨГРӨГИЙН НОГДОЛ АШИГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭДЭЭ ОЛГОНО

2005 оноос хойш 20 жилийн дараа ногдол ашиг олгохоор шийдвэрлэв



БАГАНУУР ХК НЭГ ХОНОГТ



ВАГОНЫ ТОО	ОЛБОРЛОЛТ	БОРЛУУЛАЛТ
194	13.6	650.9
ВАГОН	МЯН.ТН	САЯ.ТӨГ

САНХҮҮГИЙН ҮР ДҮН

✦ НИЙТ ОРЛОГО

Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 сарын 27-ны өдрийн 07 тоот тогтоолоор батлагдсан Бизнес төлөвлөгөөнд үндсэн үйл ажиллагаанаас 241.0 тэрбум төгрөг, үндсэн бус үйл ажиллагаанаас 3.2 тэрбум төгрөг, нийт 244.3 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн. 2024 оны гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 237.6 тэрбум төгрөг, үндсэн бус үйл ажиллагаанаас 4.9 тэрбум төгрөг, нийт 242.4 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж төлөвлөсөн орлогын 99.2%-ийн төвлөрүүлсэн.

ОРЛОГО

242.4
ТЭРБУМ.ТӨГ

ЗАРДАЛ

240.2
ТЭРБУМ.ТӨГ

ТТӨАШИГ

2.2
ТЭРБУМ.ТӨГ

ЦЭВЭР АШИГ

1.7
ТЭРБУМ.ТӨГ

✦ НИЙТ ЗАРДАЛ

2024 онд сэлбэг материал, түүхий эдийн үнэ тогтвортой байснаас гадна зардал бууруулах чиглэлээр компани бодлогын арга хэмжээ авч 251.7 тэрбум төгрөгийн зардлын төлөвлөгөөг 11.4 тэрбум төгрөгөөр хэмнэн 240.2 тэрбум төгрөгийн зардал гаргасан.

✦ ЦЭВЭР АШИГ

Компани сүүлийн хоёр жилийн хугацаанд алдагдалтай ажиллаж байсан бол 2024 онд борлуулалтын төлөвлөгөөгөө давуулан биелүүлэн, 2024 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс Дулааны цахилгаан станцуудад нийлүүлэх нүүрсний үнийг нэмэгдүүлэн, зардлыг бууруулан 1.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаа.

2022

196.4
ТЭРБУМ.ТӨГ

2023

222.1
ТЭРБУМ.ТӨГ

2024

240.2
ТЭРБУМ.ТӨГ

2022

-33.7
ТЭРБУМ.ТӨГ

2023

-9.5
ТЭРБУМ.ТӨГ

2024

1.7
ТЭРБУМ.ТӨГ

ХУДАЛДАН АВАЛТЫН ҮР ДҮН


Багануур Хувьцаат компани төрийн өмчийн оролцоотой компанийн хувьд tender.gov.mn цахим сайтаар бүх тендер шалгаруулалтаа явуулах үүрэгтэй.

Компанийн 2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд 113 тендер зарлахаар төлөвлөж 8 тендер шалгаруулалтыг хойшлуулан хэмнэлтэд оруулж 105 тендер цахимаар зарлаж 102 нь амжилттай болж гэрээ байгуулсан, 3 тендер амжилтгүй болж нийт дүнгээр 97.1% гүйцэтгэлтэй ажилласан.

2024 онд бид тендер зарлах ажлыг бизнес төлөвлөгөө батлагдсан даруйд цаг алдалгүй шуурхай зохион байгуулж “Эрдэнэс Монгол” нэгдлийн бүрэлдэхүүнд ажилладаг компаниудаас хамгийн түрүүнд буюу 2024 оны 01 сарын 18 ны өдөр эхний тендер зарласан.

2024 онд дотоодын үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр **1,078.9** сая төгрөгийн бараа материалыг Үндэсний үйлдвэрлэгчдээс худалдан авсан.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ



Багануур Хувьцаат компани 2021 онд 31 тендер шалгаруулалт явуулж 13 тендер нь л амжилттай гэрээ байгуулж байсан бол 2024 онд 105 тендер шалгаруулалт явуулж 102 тендер шалгаруулалт амжилттай болж байгаа нь компанийн санхүүгийн нөхцөл байдал сайжирч бэлтгэн нийлүүлэгчдийн өр төлбөрөө хугацаанд нь төлж санхүүгийн сахилга батыг сайжруулсантай холбоотой. Үүнээс хамааран бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын зүгээс компанид итгэх итгэл нэмэгдэж, тендер оролцогчдын тоо жил тутам олон болж байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮН

2024 онд компани нийт 36,566.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж гүйцэтгэлээр 33,805.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Техникийн шинэчлэлийн чиглэлээр 100 тонны даацтай гурван хөрс тээврийн автосамосвал, нэг дугуйт бульдозер, дөрвөн ачааны суудлын машин, хүн тээврийн хоёр автобус худалдан авсан.



ХӨРС ТЭЭВРИЙН АВТОСАМОСВАЛ

ДУГУЙТ БУЛЬДОЗЕР

Комацу HD785A-7 -
3 ширхэг

Комацу WD600A-6-
1 ширхэг

Нэг бүрийн үнэ **4,847.3 сая** Нэг бүрийн үнэ **3,270.0 сая**

Нийт үнэ **14,541.8 сая** Нийт үнэ **3,270.0 сая**

АЧАА СУУДЛЫН МАШИН

ХҮН ТЭЭВРИЙН АВТОБУС

ISUZU-
4 ширхэг

MT ISUZU-
2 ширхэг

Нэг бүрийн үнэ **106.15 сая** Нэг бүрийн үнэ **220.0 сая**

Нийт үнэ **424.6 сая** Нийт үнэ **440.0 сая**



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

“Багануур” ХК-ийн Хувьцаа санал ирээгүй, 20,147,438 ширхэг эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10:00 цагт компанийн Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газарт хуралдав. Хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа эзэмшигчдээс брокерын пүүсээр дамжуулан хуралд оролцох хувьцааг төлөөлж 4 хүн итгэмжлэлээр, 811 ширхэг хувьцаа эзэмшигч 6 хүн өөрийн биеэр нийт 20,148,249 хувьцаа эзэмшигч оролцож хурал 96.06 хувийн ирцтэй хуралдаж дараах шийдвэрүүдийг гаргасан.

1. Багануур ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж 100%-ийн саналаар батлав.
2. Компанийн дүрмийн 3.3.1 дэх хэсэг, 3.3.8 дах хэсэг, 3.3.9 дэх хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулан 99.99%-ийн саналаар батлав.
3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох кумулятив аргаар санал хураалт явуулж Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар улируулан сонгов

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
1	Эрдэнэс Монгол ХХК	15,730,770	75%
2	Монголиан Нэшнл Коал Корпорэйшн	4,416,668	21,06%
3	Жижиг хувьцаа эзэмшигчид /4538/	826,922	3,94%
Нийт		20,974,360	100%

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хурлаар сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй улируулан сонгосон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
ЧУЛУУНБААТАРЫН ДОНДОГМАА

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

БАЛЖИННЯМЫН ГЭРЛЭЭ

ДҮГЭРИЙН ЧИНБАТ

ИЧИНХОРЛООГИЙН ЛУВСАНЦЭРЭН

ЦЭРЭНПУНЦАГИЙН БОЛДБААТАР

ДАВААСАМБУУГИЙН ЭРДЭНЭБАЯР

ӨВГӨНХҮҮГИЙН ГЭРЭЛТ-ОД

МЭЛСЧОГИЙН МЭНДБАЯР

БАТААГИЙН ЧОЙЖИЛ

ДАВААДОРЖИЙН САНЧИР

БАЯРСАЙХАНЫ МӨНХЗАЯА


МӨРДОРЖИЙН ОТГОНБАЯР

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

“Багануур” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийг үндэслэн 2024 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 23.62 төгрөгөөр тооцон ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэлээ. 2024 оны санхүүгийн тайлангаар 1 тэрбум 651 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан тул цэвэр ашгийн 30 хувь буюу 495.5 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилах болсон. Компанийн хувьд 2005 оноос хойш хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг тараагаагүй байсан бөгөөд 20 жилийн дараа ногдол ашиг хуваарилах болсон. Монголын Хөрөнгийн бирж дээр 2024.01.01-ний өдрийн байдлаар “Багануур” ХК-ийн нэгж хувьцааны үнэ 788 төгрөг байсан бол 2025.02.12-ны өдрийн байдлаар 2400 төгрөг болж 304.6 хувиар нэмэгдсэн байна.


2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГААР 1 ТЭРБУМ 651 САЯ ТӨГРӨГИЙН ЦЭВЭР АШИГТАЙ АЖИЛЛАЖ 2005 ОНООС ХОЙШ 20 ЖИЛИЙН ДАРАА НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХААР БОЛЛОО

ХУВЬЦААНЫ ҮНЭ



КОМПАНИЙН БҮТЭЦ

“Багануур” ХК-ийн бүтэц зохион байгуулалтыг ТУЗ-ийн 2019 оны “Бүтэц орон тооны хязгаар батлах тухай” №22 тоот тогтоолоор баталж, Гүйцэтгэх захирлын 2024 оны А/36 тоот тушаалаар орон тоог батлаж 7 хэлтэс, 3 алба, 9 хэсгийн нийт 1122 хүний орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.



УДИРДЛАГЫН БҮТЭЦ



Д.ТҮВШИНЖАРГАЛ

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч



М.МӨНХЖАРГАЛ

Үйлдвэр технологи эрхэлсэн дэд захирал



А.ЭНХБОЛД

Техникийн бодлого эрхэлсэн дэд захирал



Д.ДАВААДАШ

Хүний хөгжил судалгаа эрхэлсэн дэд захирал



Д.ХИШИГДЭМБЭРЭЛ

Худалдаа хангамж хариуцсан хэлтсийн дарга



Т.АМАРСАНАА

Техникийн бодлогын хэлтсийн дарга



Ч.АРИУНБААТАР

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга



Ж.БОЛД-ЭРДЭНЭ

Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтсийн дарга



Ч.НАРАНБАТ

Технологийн бодлогын хэлтсийн дарга



Б.БАТБОЛД


Захиргаа хүний нөөц удирдлагын хэлтсийн дарга



Х.ХАШБАТ

Судалгаа хөгжлийн хэлтсийн дарга

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ




“ISO 45001:2018 ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГААР БАТЛАМЖЛАГДАН ФРАНЦЫН АФНОР ГРУППЭЭС ГЭРЧИЛГЭЭГЭЭ АВЛАА”

“Багануур” ХК-ийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний дагуу 2024-2028 онд хэрэгжүүлэх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны бодлогыг батлан хэрэгжүүлж эхэллээ. Бодлогын гол зорилго нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны менежментийн тогтолцоог үйлдвэрлэлийн бүх шатанд үр дүнтэй хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгахыг эрмэлзэн, аюулгүй байдлыг эрхэмлэн, зөв хандлага үйлдлээр аюул, осолгүй үйлдвэрлэл явуулж, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO45001-2018 стандартыг тасралтгүй хэрэгжүүлж нэвтрүүлж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, ногоон орчныг нэмэгдүүлэхийг чухалчлан тусгасан.

Компанийн хэрэгжүүлж буй Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо нь ISO 45001:2018 стандартын шаардлагад хэрхэн тохирч байгаа, хэр зэрэг үр нөлөөтэй, хэвийн ажиллагааг хангаж байгаа эсэхэд мониторинг, аудит хийхэд мониторингийн нэгдсэн үнэлгээгээр 90 хувьтай ХАНГАЛТТАЙ, аудитаар том үл тохирол 0, жижиг үл тохирол 0, сайжруулах санал 18 гарч нэгдсэн үнэлгээгээр ХАНГАЛТТАЙ гэсэн үзүүлэлт гарсан. Удирдлагын дүн шинжилгээний хурлаар өмнөх хурлын шийдвэрийн хэрэгжилт, тайлант хугацааны гүйцэтгэлийн хэмжилт, мониторинг, аудитын дүгнэлт, үл тохирлыг хэлэлцэн “хэрэгжүүлж буй Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандарт өгөөжтэй, эрэлт хэрэгцээг хангаж байна” гэж дүгнэсэн, Менежментийн тогтолцооны MNS ISO/IEC 17021 стандартын дагуу итгэмжлэгдсэн баталгаажуулалтын эрх бүхий “Мон сертф” ХХК-иас ISO 45001:2018 стандартын баталгаажуулалтын аудит хийж, “давуу тал 3, сайжруулах боломж 7, анхаарах хэсэг, жижиг, том үл тохирол гараагүй, менежментийн тогтолцоо, түүний гүйцэтгэл тасралтгүй сайжирч байгаа, хүлээгдэж буй үр дүнд хүрэх чадвартай” гэж дүгнэн ISO 45001:2018 стандартыг амжилттай нэвтрүүлж байна гэж үзээд “БАТАЛГААЖУУЛАЛТ”-ын сертификат гардуулсан.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЭЭЛЖИТ ҮЗЛЭГ

2024 онд компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ээлжит III шатны үзлэгийг 4 удаа хийж, 249 зөрчил илрүүлсэн нь өнгөрсөн оноос 31% өссөн, зөрчил арилгах албан шаардлагыг хэлтэс, хэсэг, нэгжийн удирдлагад өгч, илэрсэн зөрчлийн 97%-ийг бүрэн арилгуулсан.



ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

Компанийн ажлын байр, тоног төхөөрөмжүүдэд хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилтийг 100 ажлын байранд ажлын байрны шуугиан, доргион, бичил цаг уурын үзүүлэлтүүд болох агаарын урсгалын хурд, температур, харьцангуй чийглэг, гэрэлтүүлэг мөн гагнуурын утаа, тоосонцор /PM4, PM10/, агаарын чанарын зарим үзүүлэлтүүдийг шууд хэмжилтийн багажаар, нэг хүнд ноогдох талбай, эргономикийн эрсдэлийг хяналтын хуудас болон ажиглалт, тооцооллын аргаар хэмжиж үнэлэн хүйтний болон дулааны улиралд давхардсан тоогоор 354 удаа хэмжилт, үнэлгээ хийж, мэдээллийн санг үүсгэсэн. Хэмжилтээр стандартын шаардлагад үл нийцсэн 88 сөрөг хүчин зүйлийг 68 ажлын байранд илрүүлэн холбогдох хэсэг нэгжийн удирдлагыг мэдээллээр ханган сөрөг хүчин зүйлсийг бууруулах үүрэг даалгаврыг өгч үүрэг даалгаврын биелэлт 98% байна.

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДАЛТЫГ БУУРУУЛАХ, ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Амбулаториор 1500 гаруй ажилтныг үзэж зөвлөгөө өгөн, эмчилгээ сувилгаанд хамруулж, хяналтын бүлгийн 173 ажилтныг шаардлагатай үзлэг шинжилгээнд хамруулан эрүүл мэндийг сайжруулах төлөвлөгөө гаргасан.

Үүнээс эрүүл мэндийн байдал сайжирсан хувь 2.5 %, архаг өвчний намжмал буюу сэдрэлт өгөөгүй 18% байна.

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн уламжлалт нөхөн сэргээх тасагтай хамтран стационарт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай 63 хүнийг хэвтүүлэн эмчлүүлсэн.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд “Багануур” ХК нэгдэж 2030 он хүртэл “Нэг сая мод” тарьж ургуулах зорилт тавьсан.

Багануур ХК нь ногоон хөгжлийг дэмжиж, цөлжилт, газрын доройтлыг бууруулах, хүлэмжийн хийн шингээлт, усны нөөцийг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмрээ оруулж уг хөдөлгөөнд идэвх санаачилгатай оролцохын сацуу 2024 онд “Нэг сая мод” тарих стратеги төлөвлөгөөгөө боловсруулсан.

2024 онд 17000 ширхэг мод бутыг тарихаар төлөвлөж гүйцэтгэлээр 18700 ширхэг мод бутыг тариллаа.

Үүнд: Нарийны голын татмын нөхөн сэргээлтэд 5000ш, ногоон дэд бүтцэд хамгаалалтын зурвасаар 1290ш, ажилчдын амьдрах орчныг сайжруулах зорилгоор компанийн ажилчдад 6860ш, үйлдвэрийн талбайд 550ш, Богд уулын нөхөн сэргээлтэд 5000ш суулгацыг тарив.

ТАРЬСАН МОДНЫ ТӨРӨЛ

2550
УЛИАС

1600
БУРГАС

8740
ХАЙЛААС

260
ШАР ХУАЙС

5550
ШИНЭС

18700
НИЙТ

Модны тоо	2022 он	2023 он	2024 он	Нийт
Тарьсан модны тоо	10,000	11,637	18,700	40,337

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Багануур ХК 2030 он гэхэд “Нэг сая мод” тарьж ургуулна



НӨХӨН СЭРГЭЭЛТ

Уул уурхайн үйлдвэрлэлийн технологи үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг нь уурхайлалтын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажил юм.

Олборлолтын үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг тухайн орон нутгийн

орчны төрх байдалтай уялдуулан, орчны уул толгод, гүвээ давааны ерөнхий хэлбэрт аль болох төстэй байхаар хэлбэржүүлж, нөхөн сэргээлтийг бэлчээрийн зориулалтаар хийдэг.



ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Уурхайн олборлолтод өртөх талбайн шимт хөрс болон хөрсний овоолгын талбайн шимт хөрсийг уурхай байгууламжийн ажлын үе шатанд хуулна.

Олборлолтын үйл ажиллагааны явцад зам талбай, хамгаалалтын суваг, шуудуу, олборлолт гэх мэт инженерийн ажилд өртсөн, цаашид ашиглах шаардлагагүй талбайнуудыг тэгшилэн хэлбэржүүлэн засна.

БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Биологийн нөхөн сэргээлтийн хамгийн гол ажил нь ургамалжуулалт ба ургамалжуулалт нь нөхөн сэргээлт болон нөхөн сэргээгдсэн газрын ашиглалтын зорилготой нийцэхээс гадна тухайн нутгийн цаг уурын нөхцөлд тохируулан хийгдэнэ.

Биологийн нөхөн сэргээлтээр нэг болон олон наст ургамалыг 5 сарын 15-аас 6 сарын 15-ны хугацаанд хийж гүйцэтгэнэ.

АМЬТНЫ АЙМАГ



Амьтны аймгийн судалгааны ажлыг “Авралын эрэлд” ХХК-иар 2023 оны намар болон 2024 оны хавар хийлгэсэн. Хөхтөн амьтнаас Монгол тарвага, цагаан зээр, хярс үнэг, үлийн цагаан оготно, монгол чичүүл, сибирь алаг даага зэрэг 6 зүйл амьтад бүртгэгдсэн. “Хустайн байгалийн цогцолборт газар” Төв ТББ-тай 3 жилийн хугацаанд ан амьтан нутагшуулах, уурхайн ажилтнуудын байгаль хамгаалал, экологийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан. Санамж бичгийн хүрээнд Хустайн байгалийн цогцолборт газраас “Багануур” ХК-ийн эдэлбэр талбайд 40ш Монгол тарвага нутагшуулах ажлыг амжилттай зохион байгуулсан.

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ



Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Аварга тосон, Бүрд нуурын хойд эргээр хамгаалалтын зурвас мод тарьж, хашаажуулсан.

Тарьсан модны төрөл	Хашааны хэмжээ:
Улиас 340ш	Урт 440м
Шар хуайс 2573ш	Өргөн 10м
Нийт 2913 ширхэг	Талбай 4400м ²

ХОГ ХАЯГДАЛ



Дахин ашиглагдахгүй ахуйн хог хаягдлыг гурвалсан гэрээг Багануур дүүргийн Татварын алба, “Багануур тохижилт” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газартай байгуулан төвлөрсөн хогийн цэгт зайлуулан хаясан.

Аюултай хог хаягдлыг хууль тогтоомж журмын дагуу мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн. “Эко стандарт петролиум” ХХК-д 137,050л моторын масло, “Түмэн эгшиг” ХХК-д трансформаторын масло 650л, гидро масло 200л, товудны сав 175ш, тосны шүүр 500ш, “Сувдан делюкс майнинг” ХХК-д аккумулятор /том, жижиг/ 172 ширхгийг тус тус тушаасан байна.

Хүний нөөц

Статистик мэдээ

Компани нь 2024 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, стандарт, дүрэм журам, бизнес төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үндсэн 1122 ажилтаны орон тоотой ажилласан.

Үүнээс эрэгтэй эрэгтэй 976, эмэгтэй-146, жирэмсний амралттай-22 ажилтан байна. Хөдөлмөрийн хэвийн хэвийн бус нөхцөлд - 826, хэвийн нөхцөлд - 296 ажиллаж байна.

Албан тушаалын ангилалаар нь авч үзвэл удирдах албан тушаалтан - 2%, мэргэжилтэн - 3%, инженер техникийн ажилтан - 7%, дэд мэргэжилтэн -5%, туслах ажилтан - 2%, үйлчилгээний ажилтан - 10%, мэргэжлийн ажилтан - 71%-ийг эзэлж байна. Боловсролын түвшний хувьд дээд боловсролтой - 38%, бүрэн дунд - 47%, тусгай дунд - 11%, бүрэн бус дунд - 4%-ийг тус тус эзэлж байна. Үүнээс 71 ажилтан магистр, 25 ажилтан мэргэшсэн, 7 ажилтан зөвлөх инженер, 1 ажилтан докторын зэрэгтэй байна.

Боловсрол



Хүйсийн харьцаа

970

Эрэгтэй ажилтан


152

Эмэгтэй ажилтан

Насны ангилал



Ажилласан жил



■ Бүрэн бус дунд ■ Бүрэн дунд
■ Тусгай дунд ■ Дээд

ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА




Хүний нөөцийн тогтворжилтийн коэффициент

Компанийн хэмжээнд тогтворгүй байдлын коэффициент -5.7 хувьтай байна.

Харин тогтворжилтын коэффициент - 94.3 хувьтай байгаа нь харьцангуй сайн үзүүлэлт бөгөөд байгууллага хүний нөөцөө үр ашигтай удирдаж байгааг харуулж байна.

2024 онд шинээр ажилд орсон ажилтнуудын тоо



Компанийн хэмжээнд гаралтын коэффициент 11.2 хувьтай байна.

Үүнээс өндөр насны тэтгэвэр - 62, сахилгын шийтгэлээр - 10, өөрийн хүсэлтээр - 37, мэргэжлээс шалтгаалах өвчний групп-13, бусад шалтгаанаар 3 ажилтан тус тус ажлаас гарсан байна.





ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ҮР ДҮН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН

Эрдэнэс Монгол нэгдлийн эхний хагас жилийн ажлын үр дүн-өвөлжилтийн бэлтгэл” удирдах ажилтны зөвлөгөөнийг 2024 оны 08 дугаар сарын 24-ний өдөр Багануур ХК-д зохион байгууллаа. Энэхүү зөвлөгөөнд Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Н.Учрал, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Ш.Мөнхцэрэн, Гүйцэтгэх захирал С.Наранцогт нар болон нэгдлийн бүрэлдэхүүний охин, харьяа компанийн удирдлагууд оролцож, эхний хагас жилийн төлөвлөгөөт ажлын хэрэгжилт, үр дүнг үнэлэн дүгнэлээ. Мөн өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийн явцаа мэдээлж, учирч буй хүндрэл бэрхшээл, хүлээлт, шийдэл эрсэн асуудлуудаа танилцууллаа.

“Эрдэнэс Монгол нэгдэл эхний хагас жилд 3.8 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажиллав”

Багануур ХК-ийн хувьд жилийн дөрвөн улирал, 365 хоног 24 цагаар тасралтгүй ажиллаж, эх орныхоо галыг манах хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргийг биелүүлэн ажилладаг. 2024 оны эхний хагас жилд нийт 15.4 сая. м³ уулын цулын ажил хийж төлөвлөгөөг 106.2 хувиар, 9.7 сая.м³ хөрс хуулж, 2.4 сая.тн нүүрс олборлон борлуулснаар төлөвлөгөөг 102-104 хувиар биелүүлэн ажиллалаа. 2024 онд өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 3 бүлэг 31 төрлийн ажил хийхээр төлөвлөн ажиллаа.



УУРХАЙЧДЫН ЗӨВЛӨГӨӨН

Уурхайчин хамт олон та бүхэн сэтгэл итгэл, чин зүтгэл, хөдөлмөр бүтээлээрээ улс орноо гэрэлтэй гэгээтэй, галтай байлгаж байгаа.

Монгол Улсын Шадар сайд, УИХ-ын гишүүн С.Амарсайхан

Компанийн удирдлагууд ажилтнуудтайгаа жилд 2 удаа уулзаж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бодлого шийдвэр, тулгамдаж буй асуудлууд, алдаа дутагдал, амжилт ололтоо илэн далангүй ярилцаж, ажилтнуудынхаа санал хүсэлтийг сонсож, нээлттэй ярилцдаг уламжлалтай.

Багануур ХК 2024 оны хаврын зөвлөгөөнөө зохион байгуулж 2023 оны намрын зөвлөгөөнөөс хойших хугацааны үйл ажиллагаагаа нэгтгэн ярилцаж зөвлөлдлөө.

Зөвлөгөөнд Монгол Улсын Шадар сайд, УИХ-ын гишүүн С.Амарсайхан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт нар ирж оролцсон.

Шадар сайд С.Амарсайхан Монгол Улсын Ерөнхий Сайдын захирамжаар 2023 оны 12 сард байгуулагдсан “Эрчим хүчний үнэ тарифыг судлаж, зохицуулах” ажлын хэсгийг ахалж буй.

Тэрээр зөвлөгөөний үеэр уурхайчдад хандаж хэлсэн үгэндээ: Багануур ХК нүүрсний үнээс хамааралтай санхүүгийн хүндрэлтэй байгаа хэдий ч уурхайчин хамт олон та бүхэн сэтгэл итгэл, чин зүтгэл, хөдөлмөр бүтээлээрээ улс орноо гэрэлтэй гэгээтэй, галтай байлгаж байгаа. Эрчим хүчний суурилагдсан хчин чадал хязгаарлагдмал болсон, хэрэглээ улам нэмэгдсэн энэ цаг үед та бүхэн төлөвлөгөөт олборлолт нийлүүлэлтээсээ илүү нүүрсийг дулааны цахилгаан станцуудад нийлүүлэх гээд байнга өндөр хүчин чадлаар ажиллаж байна. Үүний хүчинд манай улсын эрчим хүчний салбар харьцангуй доголдол багатай явж байгаа.



Багануур ХК бол Монгол улсын эрчим хүчний салбарыг нуруундаа үүрч явдаг, төвийн эрчим хүчний нүүрсний 52%-ийг дангаараа хангадаг стратегийн ач холбогдолтой уурхай юм. С.Наранцогт





ДУНД ХУГАЦААНЫ ТЭЗҮ



3,391.2 ККАЛ/КГ

НҮҮРСНИЙ ИЛЧЛЭГ

4.5-8.5 САЯ ТОНН

НҮҮРС ОЛБОРЛОХ ХҮЧИН
ЧАДАЛ

420.6 ТЭРБУМ

УЛС ОРОН НУТГИЙН
ТӨСӨВТ

БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИ 2024-2028 ОНЫ ХООРОНД 307.5 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН НЭМЭЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙНЭ

Багануурын хүрэн нүүрсний уурхайг ашиглах дунд хугацааны техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр 2024.07.08-ны өдөр батлуулж, 2024.10.18-ны өдөр бүртгүүлсэн.

ТЭЗҮ-д тусгаснаар Багануурын уурхай 2023-2028 онд 3,391.2 ккал/кг дундаж илчлэгтэй, 36.14 сая тонн нөөцийг жилд 4.5-8.5 сая тонн нүүрс олборлох хүчин чадлаар ашиглахаар төлөвлөсөн.

Уурхайн ашиглалтын системийн сонголтыг тээвэртэй, тээвэргүй гадаад, дотоод овоолгын ашиглалтын системээс ТЭЭВЭРТЭЙ, ДОТООД ОВООЛГОТОЙ ашиглалтын системрүү шат дараатайгаар шилжүүлж, цаашид тус системээр ашиглах нь оновчтой гэж үзсэн.

Төслийн 6 жилийн хугацаанд нийт 44.9 сая.м3

ус шүүрүүлж, цуглуулан уурхайн технологи, нөхөн сэргээлт, байгаль орчны чиглэлээр болон бусад зориулалтаар зарцуулахаар тооцсон.

Дунд хугацааны ТЭЗҮ-д нийт 1,792.3 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 2,215 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, татварын өмнөх ашиг 422.8 тэрбум, татвар ногдуулсны дараах байдлаар нийт 321.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, 508.5 тэрбум төгрөгийн мөнгөн урсгалтай ажиллаж, улс орон нутгийн төсөвт 420.6 тэрбум төгрөгийн татвар төвлөрүүлж, нэгж бүтээгдэхүүний өөрийн өртөг дунджаар 49.54 мян.төг/тн байхаар төлөвлөсөн.

Төсөл хэрэгжих хугацаанд нийт 307.5 тэрбум төгрөгийн нэмэлт хөрөнгө оруулалт шийдвэрлэхээр тусгасан.



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

“БАГАНУУР” ХК, ШУТИС-ИЙН ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Түвшинжаргал, ШУТИС-ийн ГУУС-ийн захирал К.Хавалболот нарын 2023.08.24-ний өдөр үзэглэсэн санамж бичигийн хүрээнд зохион байгуулсан магистрант, докторант оюутны 2023-2024 оны хичээлийн жилийн хаврын улирлын эрдэм шинжилгээний ээлжит хурлыг Багануур ХК-ийн “Алтан уурхай” их танхимд зохион байгуулсан.

Эрдэм шинжилгээний хуралд 7 докторант, 5 магистрант оролцож илтгэл хэлэлцүүлээ. Урилгаар шинжлэх ухааны доктор, профессор Б.Пүрэвтогтох оролцож “Уул уурхайн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн чиг хандлага” сэдвээр лекц уншсан.

Эрдэм шинжилгээний хурлын шүүгчээр тус сургуулийн эрдэмтэн багш доктор, профессоруудаас гадна “Багануур” ХК-ийн Судалгаа хөгжлийн хэлтсийн дарга, Монгол улсын зөвлөх инженер, доктор Х.Хашбат, Техникийн бодлогын хэлтсийн дарга, Монгол улсын зөвлөх инженер, техникийн ухааны магистр Т.Амарсанаа, Технологийн бодлогын хэлтсийн дарга Ч.Наранбат нар ажиллалаа.



АЛТАН ЭРДЭНИЙН ЦОМ



МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВТ

50.7 ТЭРБУМ

НИЙГМИЙН ДААТГАЛД

24.0 ТЭРБУМ

Монгол улсын эрчим хүчний тулгуур уурхай Багануур ХК өсөн нэмэгдэж буй эрчим хүчний системд шаардлагатай түлшийг амжилттай нийлүүлж, үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг сайжруулсан, ашигт ажиллагааг нэмэгдүүлж, нэгдлээс зохион байгуулсан томоохон арга хэмжээнүүдэд манлайлж оролцсон үзүүлэлтээр 2024 оны Эрдэнэс Монгол нэгдлийн Менежментийн үйлчилгээг хамгийн сайн хэрэгжүүлэгч компаниар шалгарч “Алтан эрдэнийн цом”-оор шагнуулсан.

Багануур ХК нь Монгол улсын төсөвт 50.7 тэрбум төгрөгийн татвар, нийгмийн даатгалд 24.0 тэрбум төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Нүүрсний үнэ, өртгийн зөрүүнээс хоногт 130 гаруй сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан хэдий ч зөв төлөвлөж, санхүүгийн зохистой бодлого хэрэгжүүлж ажилласны үр дүнд сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд хуримтлагдсан нийгмийн даатгалын өр төлбөрийг 2024 оны 2-р сард бүрэн төлж барагдуулсан.

2019-2021 онд Монгол улсын засгийн газрын дэмжлэгтэйгээр Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны банкны зээлээр хэрэгжүүлсэн техник шинэчлэлийн 23.5 тэрбум төгрөгийн өрийг 2024 онд бүрэн төлж тэглэсэн зэрэг үзүүлэлтийг харгалзан Эрдэнэс Монгол нэгдлийн Менежментийн үйлчилгээг хамгийн сайн хэрэгжүүлэгч компаниар шалгарлаа.

ХӨХ НҮҮРС ТӨСӨЛ

Хөх нүүрсний төслийн давуу тал

- ✓ АГААРЫН БОХИРДЛЫГ БОДИТООР 80 ХҮРТЭЛХ ХУВИАР БУУРУУЛНА.
- ✓ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БУСАД ТӨСЛҮҮДТЭЙ ХАРЬЦУУЛАХАД БАГА
- ✓ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ БАГА
- ✓ БОГИНО ХУГАЦААНД ХЭРЭГЖИХ БОЛОМЖТОЙ
- ✓ СШТ-ЭЭС ҮҮСЭЖ БҮЙ АЛДАГДЛЫГ 0 БОЛГОХ БОЛОМЖТОЙ.
- ✓ БАГАНУУР ХК-ИЙН АЛДАГДАЛ БУУРАХ, ЦААШЛААД АШИГТАЙ АЖИЛЛАХ БОЛОМЖ БҮРДЭНЭ.
- ✓ ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР СТРАТЕГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД БОЛОХ ЭРЧИМ ХҮЧ, ТЭСЭЛГЭЭНИЙ ТҮҮХИЙ ЭД ҮЙЛДВЭРЛЭНЭ.
- ✓ ЦААШИД НҮҮРС-ХИМИЙН ҮЙЛДВЭРИЙН ҮНДСЭН ТҮҮХИЙ ЭД БОЛНО.

ХӨХ НҮҮРС /мян.тн/

850

КАЛЬЦИЙН КАРБИД / мян.тн/

260

НҮҮРСНИЙ ДАВИРХАЙ / мян.тн/

77.5

АММИАКИЙН ШҮҮ /мян.тн/

150

Засгийн газрын урдаа тавьсан 14 мега төслийн нэг болох “Хөх нүүрс” төслийг энэ оноос эрчимтэй урагшлуулж, 2028 хүртэл хэрэгжүүлэхээр Шинэ сэргэлтийн бодлогод тусгасан. Энэ хүрээнд Багануурын нүүрсний уурхайг түшиглэн “Нүүрс химийн цогцолбор” байгуулж, хүрэн нүүрсийг 650 градусын температурт дулааны боловсролуулалтад оруулан хагас кокс буюу хөх нүүрс үйлдвэрлэх юм. Угтаа сайжруулсан шахмал түлштэй харьцуулахад нарийн ширхэгт тоосонцор ялгарлын хэмжээг 80 хувиар бууруулж, хүхрийн исэл 64, акотын исэл 85 хувиар багасана гэж тооцож буй. Урьдчилсан судалгаагаар, үйлдвэр ашиглалтад орсноор 850 гаруй мянган тонн хөх нүүрс үйлдвэрлэж, 600 гаруй мянган тонныг нь Улаанбаатар хотын айл өрхөд нийлүүлэхээр тооцжээ. Харин 200 гаруй мянган тонныг нь Дарханы төмөрлөгийн үйлдвэр болоод бусад аж ахуй нэгж орон нутагт нийлүүлэх юм. Хөх нүүрс нь түүхий нүүрсэнд агуулагдах хорт нэгдлүүдийн хэмжээг бууруулж, хотын агаарын чанарыг сайжруулах бөгөөд богино хугацаанд хэрэгжих боломжтой төсөл гэдгээр нь онцолж гаргаж ирсэн. Эдийн засгийн хувьд хэмнэлттэй, өртөг нь одоогийн сайжруулсан түлшээс 62 хувиар хямд байна гэж тооцоолж байгаа.



БАГАНУУР ДҮҮРГИЙН 2024 ОНЫ ШИЛДЭГ ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ “БАГАНУУР” ХК

Багануур дүүргийн оны шилдэг байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллага, хувь хүмүүсийг тодруулах “BAGANUUR AWARDS-2024” шагнал гардуулах ёслолын арга хэмжээ болж дүүргийн 2024 оны ШИЛДЭГ ҮЙЛДВЭР АЖ АХУЙН НЭГЖ номинацид Эрдэнэс Монгол нэгдлийн гишүүн, Монгол Улсын эрчим хүчний тулгуур уурхай Багануур ХК шалгарлаа.

Багануур ХК-ийн уурхайчин хамт олон эрчим хүчний салбарын өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэхийн зэрэгцээ 2024 онд нийгмийн хариуцлагын хүрээнд дүүрэг орон нутгийн хөгжил, хүүхэд залуус, гэр бүлд чиглэсэн олон ажил зохион байгуулсаныг өндөрөөр үнэлсэн юм.



“ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ” АЯН



Д.НЯМСАМБУУ

- Гавж
- Жавзандамба хутагт төвийн багш
- “Оксфорд Майндфулнэсс” санамсрын бясалгалын хөтөч

“Харилцан хүндэтгэе” нөлөөллийн аяны хүрээнд Уурхайчид болон тэдний гэр бүлд зориулан Жавзандамба хутагт төвийн багш, гавж Д.Нямсамбуу “Оксфорд Майндфулнэсс” санамсрын бясалгалын талаар лекцийг нийт ажилтнуудад сонсголоо. 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 24-ны хооронд 2 сарын хугацаанд “Уурхайчин” спорт цогцолборын зааланд уурхайчид болон тэдний гэр бүлд зориулан 9 цуврал лекц, бясалгалын хичээлийг орлоо.

- Автомат жолоодлогоос сэрэхүй
- Биеийг сэтгэлдээ агуулахуй
- Сарнисан оюуныг цуглуулахуй
- Автомат хариултыг танин барихуй
- Явуулах, хүлээн зөвшөөрөх
- Уран хариулт буюу бодол бол баримт биш
- Дасгалын өдөр
- Хэрхэн өөрийгөө хамгийн сайн анхаарах вэ
- Насан туршийн санамсарын бясалгал

сэдвүүдийн хүрээнд давхардсан тоогоор 1091 уурхайчин, тэдний гэр бүл хамрагдсан байна.


“Mining week & MinePro-2024”

“Mining week & MinePro-2024” олон улсын үзэсгэлэн, чуулга уулзалт 10 дугаар сарын 2-6-нд Налайх дүүргийн Тайж хайрханы бэлд зохиогдож, “Эрдэнэс Монгол” нэгдлийн нийт бүрэлдэхүүн компаниуд нэгэн дээвэр дор нэгдсэн зохион байгуулалттайгаар амжилттай оролцлоо.

Багануур ХК нь олборлолтын үйл ажиллагаагаа сурталчлан цаашид хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүддээ танилцууллаа. “Эрдэнэс Монгол” нэгдлийн асраар 8000 гаруй зочид төлөөлөгч нар зочилж, УИХ-ын гишүүд, аж ахуйн нэгжүүд болон Хятад, Канад, Австрали зэрэг 20 гаруй орны төлөөлөл, Элчин сайдын яамд, худалдааны танхимууд зэрэг уул уурхайн дотоодын 50 гаруй компани, олон улсын 30 гаруй байгууллагын төлөөлөл оролцлоо.

Багануур ХК-ийн талбайд гадаадын 80 гаруй, дотоодын 200 гаруй байгууллагын 2000 гаруй зочид, оюутан сурагч нар зочилж, нээлттэй мэдээлэл хүлээн авлаа. Mining week & MinePro-2024 арга хэмжээний үеэр Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци, Монголын Уул Уурхайн Операторуудын Холбоод хамтран, хүнд машин механизмын операторуудын шилдгийн шилдэг, аварга шалгаруулах “National Operator Challenge” тэмцээн зохион байгуулж Экскаватор, Трак, Лодер, Грейдер гэсэн 4 төрлийн хүнд даацын техникийн ур чадвараар өрсөлдүүлснээс Багануур ХК-ийн нэрийн өмнөөс оролцсон манай компанийн ажилтнууд дараах амжилтыг гарган оролцлоо.

- Dump track төрөлд Технологийн авто машин ашиглалтын хэсгийн оператор жолооч Г.Энххуяг тэргүүн байр алтан медаль
- Autograder төрөлд Технологийн авто машин ашиглалтын хэсгийн авто грейдрийн оператор Д.Бат-Эрдэнэ
- Экскаваторын төрөлд Технологийн авто машин ашиглалтын хэсгийн оператор Х.Энэрэл гутгаар байр хүрэл медаль гэсэн амжилтуудыг гарган оролцлоо.



ЭРҮҮЛ УУРХАЙЧИН ХӨТӨЛБӨР

Багануур ХК-ийн Уурхайчин спорт цогцолборт 2024 онд Улс, хот, бүсийн чанартай 7 тэмцээн уралдаан, дүүрэг орон нутаг, аж ахуй нэгж байгууллагуудын дундах 9 тэмцээн уралдаан, компанийн дотоод хэсэг нэгжүүдийн дундах 25 тэмцээн уралдаан, спортын арга хэмжээ зохион байгуулагдсан байна.

1

XV-р Спортын их наадам

Хоёр жил тутам болдог Уурхайчдын спортын их наадам 2024 онд “Эв нэгдэл - эерэг хандлага - эрүүл уурхайчин” уриан дор зохион байгуулагдлаа. Уурхайчдын спортын наадмыг 4 дүгээр сараас эхлүүлэн бүтэн жилийн турш 9 хэсгийн дунд 660 гаруй уурхайчин тамирчин спортын 18 төрлөөр амжилттай өрсөлдөж спортын шилдэг хэсэг, шилдэг тамирчдаа тодрууллаа. Энэ удаагийн спортын наадам эрүүл уурхайчин хөтөлбөрийн хүрээнд цогц байдлаар бүтэн жилийн турш үргэлжилсэн нь онцлог байлаа.

3

Хөдөлгөөн засал

“Эрүүл уурхайчин” хөтөлбөрийн хүрээнд уурхайчин спорт цогцолбороос уурхайчдын дунд түгээмэл тохиолддог нурууны өвдөлтийг бууруулах зорилгоор Хөдөлгөөн заслын төлөвлөгөө гарган ажилласан. “Бие бялдрын түвшин тогтоох сорилыг” 2024 оны 4 сарын 15 - 5 сарын 1 хооронд нийт ажилтнуудаас 16 хоногийн хугацаанд авсан. 9 хэсэг, 11 хэлтэс албаны нийт 1019 ажилтан хамрагдсан байна.

2

Сэтгэл зүйч

Багануур ХК 2024 онд сэтгэл зүйчийн шинэ ажлын байр бий болгож ажилтнууддаа мэргэжлийн сэтгэл зүйн зөвлөгөө хүргэн ажиллаа. 2024 оны байдлаар 32 ажилтан Сэтгэл зүйн зөвлөгөөнд тогтмол хамрагдсанаас гадна уурхайчдын сэтгэл зүйн суурь үзүүлэлттэй холбоо бүхий судалгааг хийж, Хэлтэс, алба, хэсгийн дарга нартай сэтгэл зүйч, хуулийн зөвлөх, нийгмийн ажилтан нар хамтран “Дөрвөлсөн уулзалт”-ыг зохион байгуулж ажилласан. Тус уулзалт нь архи согтууруулах ундаа, цахим мөрийтэй тоглоом, гэр бүлийн харилцааны асуудлыг тодорхойлон түүнээс сэргийлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулахад чиглэсэн.

4

Спорт цогцолбор

Уурхайчин спорт цогцолбороор давхардсан тоогоор 2024 онд 2744 ажилтан хамрагдан спортоор хичээллэсэн байна. Уурхайчин Спорт цогцолборын дэргэдэх клубууд үйл ажиллагаагаа тогтмол явуулж ажилтнууд спортын олон төрлөөр хичээллэж Улсын болоод Олон улсын чанартай тэмцээн уралдаануудад амжилт гаргаж байна.



НҮҮРСНИЙ ҮНЭ ТАРИФ

Багануурын уурхайн санаачилгаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн “Түлш эрчим хүчний групп”-тэй хамтран “Эрчим хүчний салбарын зөвлөлдөх уулзалт”-ыг 2024 оны 05 сарын 07-ны өдөр зохион байгуулж, тус уулзалтад Эрчим хүчний яам, Эрдэнэс Монгол ХХК, Эрчим хүчний зохицуулах хороо болоод ДЦС-4,3,2, ДДЦС, Амгалан ДС, Шивээ-Овоо ХК-иуд оролцсон.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, олон нийт бодит нөхцөл байдлыг ойлгож эрчим хүч болон нүүрсний үнэ нэмэхийг дэмжсэнээр Багануур ХК-ийн Дулааны болон цахилгаан станцуудад борлуулж буй нэг тонн нүүрсний суурь үнийг 24.8%-иар буюу 10,781 төгрөгөөр нэмэгдүүлж 54,091 төгрөгт хүргэсэн нь үнийг бодит өртөгт хүргэсэн томоохон дэмжлэг боллоо. Үүнээс гадна жижиглэнгийн нүүрсний үнийг ТУЗ-ийн шийдвэрээр 14.3%-иар буюу 7,500 төгрөгөөр нэмэгдүүлж 60,000 төгрөгт хүргэсэн нь компани ашигтай үнээр нүүрсээ хэрэглэгчдэд борлуулах түүхэн шийдвэр байлаа.



УУЛЗАЛТ

“Түлш, эрчим хүчний найдвартай байдлыг хангах, үнэ тариф, уурхайн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр” 2024 оны 1-3 сарын хооронд ЭХЗХ, ЭХЯ, УУХҮЯ, Монгол Улсын Шадар сайдын түвшинд нийт 7 удаагийн уулзалтыг хийсэн.

ХЭЛЭЛЦЭЭР

Эрчим хүчний зохицуулах хороонд нүүрсний үнэ нэмэгдүүлэх тухай албан бичгийг нотлох баримтын хамт 3 удаа, 2024 оны 3 сарын 22-ны өдөр ЭХЗХ-ны удирдлагуудтай “Багануурын уурхайн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал”, “Нүүрсний үнийг нэмэгдүүлэх, эсхүл үнийн зөрүүний алдагдалд төрөөс татаас авах” асуудлын хүрээнд уулзалт хэлэлцээр хийсэн.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15180
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.21 № 07/1132
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд хөрс хуулалт, нүүрс тээврийн үйл ажиллагаанд нэн шаардлагатай машин, тоног төхөөрөмжийг шинээр худалдан авч, сүүлийн жилүүдэд хийгдээгүй байсан технологийн авто машинуудын хөдөлгүүр болон их засваруудыг хийж, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд нийт 33,643.4 сая төгрөг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд нийт 244,296.3 сая төгрөг орлого олж, 251,657.0 сая төгрөг зардал гарган 7,360.7 сая төгрөг алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 241,590.0 сая төгрөг орлого олж, 239,938.4 сая төгрөг зардал гарган 1,651.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 36,566.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 33,643.4 сая төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 588 дугаар тогтоолоор 1 тонн нүүрсний үнийг 43,310.00 төгрөгөөр баталсан байсныг 2024 оны 694 дүгээр тогтоолоор 54,091.00 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,417,234,743.19	6,366,982,530.30
1.1.2	Дансны авлага	4,547,818,310.13	4,690,594,574.18
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	27,915,379.57	2,640,878.45
1.1.4	Бусад авлага	3,646,675,927.60	1,951,272,638.91
1.1.6	Бараа материал	49,354,185,876.94	49,105,511,778.26
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	2,311,999,968.54
	Эргэлтийн хөрөнгийн дүн	59,993,830,237.43	64,429,002,368.64
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	169,952,205,306.91	168,599,587,652.46
1.2.2	Биет бус хөрөнгө	4,600,596,254.79	4,616,514,877.36
1.2.3	Уул уурхайн хөрөнгө /Хөрс хуулалт/	25,563,066,622.70	25,169,955,715.80
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	999,767,331.34	615,704,292.34
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	764,393,387.00	764,393,387.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	3,609,958,909.70	1,328,603,776.54
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	205,489,987,812.44	201,094,759,701.50
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	265,483,818,049.87	265,523,762,070.14
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	60,720,143,664.51	62,906,234,850.58
2.1.1.2	Цалингийн өглөг	2,616,642,414.86	2,589,819,924.00
2.1.1.3	Татварын өр	53,284,067,637.36	76,622,743,330.34
2.1.1.4	НДШ-ийн өглөг	8,287,925,455.68	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	3,766,628,727.10	13,356,223,186.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	12,968,712.50	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,640,742,814.39	1,550,967,618.04
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	50,788,049.31	97,299,475.59
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	130,379,907,475.71	157,123,288,384.55
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	102,185,389,999.85	91,243,334,940.28
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	1,167,266,443.09	1,167,266,443.09
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	9,187,960,486.21	9,136,501,019.22
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	112,540,616,929.15	101,547,102,402.59
2.2	Өр төлбөрийн нийт дүн	242,920,524,404.86	258,670,390,787.14
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:- төрийн	1,573,077,000.00	1,573,077,000.00
2.3.2	- хувийн	524,359,000.00	524,359,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	60,685,388,076.98	63,295,572,091.86
2.3.8	Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	-	3,702,426,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(40,219,530,431.97)	(62,242,062,808.86)
2.3.11	Эздийн өмчийн дүн	22,563,293,645.01	6,853,371,283.00
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	265,483,818,049.87	265,523,762,070.14

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	210,096,473,086.23	237,581,225,691.92
2	Борлуулалтын өртөг	204,142,122,501.47	217,369,427,229.47
3	Нийт ашиг(алдагдал)	5,954,350,584.76	20,211,798,462.45
4	Түрээсийн орлого	34,070,947.73	45,081,745.46
5	Хүүгийн орлого	13,894,581.72	23,265,228.67
6	Ногдол ашгийн орлого	12,863,696.52	377,061,963.56
8	Бусад орлого	386,737,611.97	2,744,391,353.17
9	Борлуулалт, маркетингийн зардал	647,053,456.31	694,205,527.44
10	Ерөнхий ба удирдлагын зардал	13,265,655,474.83	15,975,522,292.00
11	Санхүүгийн зардал	2,685,116,635.38	4,008,421,198.11
12	Бусад зардал	885,872,898.97	1,335,828,392.78
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	1,566,308,195.77	819,020,429.18
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(9,515,472,847.02)	2,206,641,772.16
19	Орлогын татварын зардал	1,389,458.17	554,984,490.04
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(9,516,862,305.19)	1,651,657,282.12
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(9,516,862,305.19)	1,651,657,282.12
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Орлогын нийт дүн	(9,516,862,305.19)	1,651,657,282.12
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

/төгрөгөөр/

Багануур ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	(28,546,450,831.52)	34,236,373,245.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	(28,546,450,831.52)	34,236,373,245.46
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	-	-	-	(9,516,862,305.19)	(9,516,862,305.19)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	(2,156,217,295.26)	(2,156,217,295.26)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	(40,219,530,431.97)	22,563,293,645.01
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	(40,219,530,431.97)	22,563,293,645.01
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	2,610,184,014.88	3,702,426,000.00	(23,674,189,659.01)	(17,361,579,644.13)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,651,657,282.12	1,651,657,282.12
2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	63,295,572,091.86	3,702,426,000.00	(62,242,062,808.86)	6,853,371,283.00

/төгрөгөөр/

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	211,205,772,188.83	236,751,140,252.90
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	210,909,990,145.16	236,221,865,182.01
1.1.4	Буцаан авсан албан татвар	269,520,748.42	384,739,247.55
1.1.6	Бусад мөнгөн орлого	26,261,295.25	144,535,823.34
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	201,263,308,232.25	215,058,086,616.04
1.2.1	Ажиллагчдад төлсөн	41,605,342,476.92	48,219,477,862.73
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	17,278,689,407.40	23,876,227,349.56
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	77,268,930,989.11	77,030,502,580.61
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	104,500.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	50,828,908,506.36	49,102,924,244.98
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	1,044,881,385.10	429,205,919.32
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	10,856,724,554.40	10,059,756,471.33
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,379,830,912.96	6,339,887,687.51
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	9,942,463,956.58	21,693,053,636.86
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	13,801,304.98	23,257,056.10
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	13,801,304.98	23,257,056.10
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	25,517,179,533.48	20,602,209,836.06
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	25,406,785,735.48	20,337,117,651.70
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	110,393,798.00	265,092,184.36
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(25,503,378,228.50)	(20,578,952,779.96)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	55,004,840,525.00	40,071,275,287.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	55,004,840,525.00	40,071,275,287.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	41,008,796,217.77	37,235,569,846.79
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	41,008,796,217.77	37,235,569,846.79
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,996,044,307.23	2,835,646,930.21
4	Валютын ханшийн зөрүү	(218,824.17)	(58,510.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,565,088,788.86)	3,949,747,787.11
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,982,323,532.05	2,417,234,743.19
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,417,234,743.19	6,366,982,530.30

